



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 21/71

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2, 13.3.5, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Польш Улсаас нийлүүлсэн автомашин, техник, тоног төхөөрөмжийг эзэмшиж, ашиглах салаан захирагч, гал унтраах автомашины жолооч, гал сөнөөгчдийг дадлагажуулах, ажлын хариуцлага, аюулгүй ажиллагааг хангах, гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдал, мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх зорилгоор 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдөр сургалтыг зохион байгуулсугай.
2. Сургалтын удирдамжийг нэгдүгээр, сургалтад оролцох алба хаагчдын нэрийг хоёрдугаар, шаардлагатай зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалт зохион байгуулахад шаардагдах 25.000 (хорин таван мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.
4. Удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх хэлтэс (хурандаа Д.Мөнхсайхан)-т үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА

Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



СУРГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

Сургалтын зорилго: Польш улсаас дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах ангиудад нийлүүлэгдсэн автомашин, техник, тоног төхөөрөмжийг эзэмших, ашиглах салааны захирагч, гал унтраах автомашины жолооч, гал сөнөөгчдийг дадлагажуулах ажлын хариуцлага, аюулгүй ажиллагааг хангах, мэргэжлийн ур чадвар, гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ

Нэг. Нийтлэг зүйл

Сургалтыг гал түймэр унтраах, аврах ангийн өдөр тутмын үйл ажиллагаа, цагийн хуваарьт заагдсан ажил үйлчилгээ, гал унтраах бэлтгэл бэлэн байдлын чадавхыг алдагдуулахгүйгээр ажлын 1 өдөрт багтаан зохион байгуулалт сайтай явуулах бөгөөд тухайн ангийн салааны захирагч, гал унтраах автомашины жолооч, гал сөнөөгч бүрэлдэхүүн бүрэн хамрагдсан байна.

1.1 Гал түймэр унтраах, аврах ангийн салааны захирагч, гал унтраах автомашины жолооч, гал сөнөөгч нар хээрийн хувцас, жолооны үнэмлэх бичиг баримттай, бичиг тэмдэглэх бал дэвтэртэй байна.

1.2 Сургалтын үед албан хаагчдын ирц, сахилга, дэг журам, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг чанд сахин биелүүлэх ба хариуцсан инженер механикууд хариуцаж, хяналт тавина.

1.3 Сургалтанд оролцох бүрэлдэхүүн 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 09.00 цагт сургалт явагдах тухайн анги салбарын жагсаалын талбайд бэлэн жагссан байна.

1.4 Сургалтын явцад албан хаагчид хичээл сургууль явуулж байгаа удирдагчийн тавьсан шаардлага, өгсөн үүргийг ягштал биелүүлж, сургалтыг үр бүтээлтэй өгөөжтэй болгоход бүх талын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Хоёр. Хичээлийн бүтэц, цагийн хуваарь

д/д	Хичээлийн сэдэв	Цагийн хуваарь	Хариуцах нэгж, албан тушаалтан
2019 оны 07 дугаар сарын 19-ний өдөр, Баасан гараг			
1	Бүртгэл /тухайн анги салбарын жагсаалын	09.00-09.10	Дүүргүүдийн инженер механикууд,

	талбайд/		Ангийн захирагч
	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулах	09.15-09.35	Ангийн захирагч
2	Танхимын хичээл	09.35-10.35	Дүүргүүдийн автын инженер, механикууд
3	Дадлага сургууль хийх	10.35-16.30	Дүүргийн автын инженер механик
4	Үүрэг даалгавар өгөх	16.30-17.00	Нийслэлийн Онцгой байдлын газар /хурандаа Д.Мөнхсайхан/

Гурав. Дадлага, сургалтын үйл явц

Гал унтраах тусгай зориулалтын автомашины ус шахах насос, усан хөөрөг гал унтраах багаж тоног төхөөрөмжийг ажиллуулах анхан шатны мэдлэг олгох тэдгээрийг дадлагажуулах, бүх албан хаагчдийг нэг бүрчлэн хамруулна.

Дөрөв. Зохион байгуулагдах газар

- Жагсах талбай- Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 63 дугаар анги,
Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 34, 74 дүгээр анги,
Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 14 дүгээр ангийн жагсаалын талбайд тус тус жагсана.
- Дадлага сургуулилт зохион байгуулагдах газар- Тухайн анги салбарын жагсаалын талбай /сургалтын танхим/

Тав. Сургалтын дүн гаргах

4.1. Сургалтын явцад албан хаагчид нь дадлагаар олж авсан мэдлэг, туршлагаа хичээлийн конспектоор бичиж тэмдэглэн ангийн захирагчаар хянуулж гарын үсэг зуруулж баталгаажуулна.

4.2. Сургалтын зардлын санхүүгийн материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж Санхүү, эдийн засгийн хэлтэст гаргаж өгөх

4.3. Сургалтын явц, үр дүнгийн талаар илтгэх хуудсаар Нийслэлийн онцгой байдлын газрын даргад 2019 оны 07 дугаар сарын 25-ны дотор танилцуулна.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн
01/21 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

СУРГАЛТЫН ЯВЦАД УДИРДЛАГААР ХАНГАХ
БОЛОН ХИЧЭЭЛ ЗААХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС

д/д	Дүүрэг	Анги	Албан хаагчийн		Оролцоо
			Цол	Нэр	
1	НОБГ	ГТТХ	хурандаа	Д.Мөнхсайхан	Нэгдсэн удирдлагаар хангах
2	НОБГ	ГТТХ	ахмад	О.Мөнхбат	Зохион байгуулалтаар хангах
3	НОБГ	ГТТХ	д/ч	Д.Батболд	Хичээл заах
4	НОБГ	ГТТХ	А/а	Д.Бархас	Жолооч
5	Баянзүрх	ОБХ	ахмад	Ш.Ганзориг	Хичээл заах
6	Хан-Уул	ОБХ	ахмад	Ж.Ганхуяг	Хичээл заах
7	Сүхбаатар	ОБХ	Д/ч	Ч.Нямдорж	Хичээл заах
8	Сүхбаатар	ГТУА 34-р анги	А/а	Г.Энхтүвшин	Хичээл заах
9			А/а	Б.Мөнх-Эрдэнэ	Хичээл заах
10		ГТУА 74-р анги	А/а	С.Энхтөр	Хичээл заах
11			А/а	Б.Болд	Хичээл заах
12	Баянзүрх	ГТУА 63-р анги	А/ч	Г.Лхагва-Очир	Хичээл заах
13			А/а	Т.Гантулга	Хичээл заах
14		ГТУА 35-р анги	Д/а	Д.Амарсанаа	Хичээл заах
15	Хан-Уул	ГТУА 30-р анги	Д/а	Б.Дашдорж	Хичээл заах
16		ГТУА 65-р анги	А/ч	Н.Алдаржав	Хичээл заах
17		ГТУА 14-р анги	А/а	Т.Бавуу-Очир	Хичээл заах
18			А/ч	Б.Болдсайхан	Хичээл заах

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн
д/т.г. дугаар тушаалын гуравдугаар хавсралт

СУРГАЛТАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/Д	Зардлын нэр	Зориулалт	Нэгж үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Шатахуун	08-42 УНУ улсын дугаартай автомашин		1 нэгж техник	25,000
Нийт дүн					25,000

-oOo-